



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

“Агула даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын
албан журмын даатгалын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.2, 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Агула даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Салбараа нээгээгүй аймагт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг аливаа хэлбэрээр эрхлэн явуулахыг “Агула даатгал” ХХК-д хориглосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН